ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2021/1/СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Э.Батчимэг

Утас: 99032916

Цахим хаяг: ij17.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....14
3. Аудитын тайлан....15
3.1. Ерөнхий зүйл....15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....15
3.4. Материаллаг байдал ....16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....17
3.7. Шилэн дансны мэдээлэл....17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....18
3.9. Аудитын илрүүлэлт....18
Аудитын зөвлөмж....18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....18
4. Менежментийн захидал....19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....19

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.26 № 1-6/215

танай ____________-ны №______________-т

АЙРАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ О.ОДОНЧИМЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **140,151,296.05** | **163,996,358.42** |
| **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | |
| Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | | |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| **АВЛАГА** | 1,500,000.00 | 13,526,880.00 |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | | 13,526,880.00 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 1,500,000.00 | |
| **УРЬДЧИЛГАА** | | |
| **БАРАА МАТЕРИАЛ** | 138,651,296.05 | 150,469,478.42 |
| Түүхий эд материал | 6,652,153.92 | 6,723,463.92 |
| Тусгай зориулалттай материал | 6,053,764.92 | 6,053,764.92 |
| Эм боох материал | 598,389.00 | 669,699.00 |
| Хангамжийн материал | 131,704,942.13 | 137,916,014.50 |
| Бичиг хэргийн материал | 1,193,120.00 | 2,124,070.00 |
| Аж ахуйн материал | 3,703,548.00 | 3,588,448.00 |
| Түлш, шатах тослох материал | 269,100.00 | 691,400.00 |
| Барилгын засварын материал | 2,051,920.00 | 5,659,550.00 |
| Хүнсний материал | 3,053,146.00 | 389,900.00 |
| Бусад хангамжийн материал | 121,434,108.13 | 125,462,646.50 |
| Мал амьтад | 294,200.00 | 5,830,000.00 |
| **НӨӨЦИЙН БАРАА** | | |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,719,476,189.39** | **2,767,120,688.56** |
| **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,719,476,189.39 | 2,767,120,688.56 |
| Биет хөрөнгө | 2,674,076,189.39 | 2,720,137,605.20 |
| Барилга, байгууламж, орон сууц | 2,461,891,899.49 | 2,461,891,899.49 |
| Хуримтлагдсан элэгдэл | (55,446,707.40) | (96,244,991.28) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 219,714,926.72 | 225,141,278.72 |
| Хуримтлагдсан элэгдэл | (147,588,319.09) | (120,518,001.42) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 131,990,771.53 | 125,285,523.53 |
| Хуримтлагдсан элэгдэл | (49,050,550.35) | (46,728,077.25) |
| Бусад үндсэн хөрөнгө | 62,136,314.88 | 119,657,949.88 |
| Хуримтлагдсан элэгдэл | (3,935,666.23) | (7,243,740.31) |
| Ном | 54,363,519.84 | 58,895,763.84 |
| Биет бус хөрөнгө | 45,400,000.00 | 46,983,083.36 |
| Програм хангамж | 510,000.00 | 2,237,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (510,000.00) | (653,916.64) |

| | | |
|---|---|---|
| Бусад биет бус хөрөнгө | 45,400,000.00 | 45,400,000.00 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,859,627,485.44** | **2,931,117,046.98** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,500,000.00** | **122,000.00** |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,500,000.00 | 122,000.00 |
| Өглөг | 1,500,000.00 | 122,000.00 |
| Бусад өглөг | 1,500,000.00 | 122,000.00 |
| Байгууллагад төлөх өглөг | 1,500,000.00 | 122,000.00 |
| Урьдчилж орсон орлого | | |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | |
| Урт хугацаат зээл | | |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,858,127,485.44** | **2,930,995,046.98** |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 2,858,127,485.44 | 2,930,995,046.98 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 528,838,633.66 | 528,838,633.66 |
| Өмч: - төрийн | | |
| Хуримтлагдсан үр дүн | 1,779,344,756.30 | 1,852,212,317.84 |
| Өмнөх үеийн үр дүн | 1,779,344,756.30 | 1,779,344,756.30 |
| Тайлант үеийн үр дүн | | 72,867,561.54 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 549,944,095.48 | 549,944,095.48 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,859,627,485.44** | **2,931,117,046.98** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,081,639,538.43** | **1,168,780,486.37** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **84,464,708.43** | **161,902,891.37** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 84,464,708.43 | 161,902,891.37 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 84,464,708.43 | 9,846,481.87 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,723,676.00 | 549,420.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 81,741,032.43 | 9,297,061.87 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 150,982,433.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 1,073,976.50 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **997,174,830.00** | **1,006,877,595.00** |
| **Улсын төвлөрсөн төсвөөс** | 774,670,900.00 | 810,218,500.00 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 774,670,900.00 | 810,218,500.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,278,630.00 | 3,442,200.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 500,000.00 | |

| | | |
|---|---|---|
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,778,630.00 | 3,442,200.00 |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 218,225,300.00 | 193,216,895.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 218,225,300.00 | 193,216,895.00 |
| **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,074,968,458.26** | **1,095,912,924.83** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,074,968,458.26** | **1,095,912,924.83** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,034,088,891.27 | 1,063,026,795.69 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 598,056,713.00 | 655,985,220.00 |
| Үндсэн цалин | 397,240,873.00 | 415,658,220.00 |
| Нэмэгдэл | 139,798,500.00 | 169,409,500.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 15,574,683.00 | 24,150,000.00 |
| Урамшуулал | 45,442,657.00 | 46,767,500.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,236,969.01 | 82,091,366.86 |
| Тэтгэврийн даатгал | 51,163,898.01 | 57,731,366.86 |
| Тэтгэмжийн даатгал | 5,177,000.00 | 6,089,500.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 5,683,969.00 | 4,871,800.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,207,692.00 | 1,217,800.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,004,410.00 | 12,180,900.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 212,781,917.00 | 190,234,145.00 |
| Гэрэл, цахилгаан | 9,320,616.00 | 5,606,785.00 |
| Түлш, халаалт | 193,334,900.00 | 179,298,300.00 |
| Цэвэр, бохир ус | 10,126,401.00 | 5,329,060.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 7,061,803.00 | 13,979,934.00 |
| Бичиг хэрэг | 1,144,720.00 | 1,407,930.00 |
| Тээвэр, шатахуун | 1,271,541.00 | 819,450.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,537,262.00 | 1,016,110.00 |
| Ном, хэвлэл | | 2,720,200.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,650,400.00 | 3,648,494.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,457,880.00 | 4,367,750.00 |
| **Нормативт зардал** | 24,648,927.50 | 10,846,611.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 124,560.00 | 409,890.00 |
| Хоол, хүнс | 21,890,567.50 | 9,983,421.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,633,800.00 | 453,300.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,289,640.00 | 717,120.00 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 55,000.00 |
| Урсгал засвар | 2,289,640.00 | 662,120.00 |
| Томилолт, зочны зардал | 1,850,000.00 | 903,800.00 |

| | | |
|---|---|---|
| Дотоод албан томилолт | 1,850,000.00 | 903,800.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,015,622.00 | 1,445,800.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,015,622.00 | 1,205,800.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 240,000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 110,147,299.76 | 106,822,798.83 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,934,261.00 | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,875,480.00 | 2,227,465.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 94,337,558.76 | 104,595,333.83 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,879,566.99** | **32,886,129.14** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 33,807,400.00 | 19,921,500.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,866,400.00 | 19,021,500.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,941,000.00 | 900,000.00 |
| **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,218,463.00 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,218,463.00 | |
| **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,853,703.99 | 12,964,629.14 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,853,703.99 | 12,964,629.14 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **Дотоод эх үүсвэрээр** | | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **6,671,080.17** | **72,867,561.54** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **107,186.55** | |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 107,186.55 | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(107,186.55)** | |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6,563,893.62** | **72,867,561.54** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,001,398,506.00** | **1,008,927,015.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,723,676.00** | **549,420.00** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 2,723,676.00 | 549,420.00 |
| **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,723,676.00 | 549,420.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,723,676.00 | 549,420.00 |

| | | |
|---|---|---|
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **998,674,830.00** | **1,008,377,595.00** |
| **Улсын төвлөрсөн төсвөөс** | 774,670,900.00 | 810,218,500.00 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 774,670,900.00 | 810,218,500.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,778,630.00 | 4,942,200.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 500,000.00 | |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,278,630.00 | 4,942,200.00 |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 218,225,300.00 | 193,216,895.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 218,225,300.00 | 193,216,895.00 |
| **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **972,023,410.00** | **1,007,669,615.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **972,023,410.00** | **1,007,669,615.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **929,643,843.01** | **973,283,485.86** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 598,056,713.00 | 669,512,100.00 |
| Үндсэн цалин | 397,240,873.00 | 429,185,100.00 |
| Нэмэгдэл | 139,798,500.00 | 169,409,500.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 15,574,683.00 | 24,150,000.00 |
| Урамшуулал | 45,442,657.00 | 46,767,500.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,927,207.01 | 82,091,366.86 |
| Тэтгэврийн даатгал | 50,854,136.01 | 57,731,366.86 |
| Тэтгэмжийн даатгал | 5,177,000.00 | 6,089,500.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 5,683,969.00 | 4,871,800.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,207,692.00 | 1,217,800.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,004,410.00 | 12,180,900.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 212,478,317.00 | 190,234,145.00 |
| Гэрэл, цахилгаан | 9,320,616.00 | 5,606,785.00 |
| Түлш, халаалт | 193,031,300.00 | 179,298,300.00 |
| Цэвэр, бохир ус | 10,126,401.00 | 5,329,060.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 8,957,803.00 | 10,888,394.00 |
| Бичиг хэрэг | 933,600.00 | 584,300.00 |
| Тээвэр, шатахуун | 1,349,241.00 | 1,241,750.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,537,262.00 | 818,200.00 |
| Ном, хэвлэл | | 2,720,200.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,650,400.00 | 4,032,494.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,487,300.00 | 1,491,450.00 |
| **Нормативт зардал** | 18,610,601.00 | 8,775,175.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 410,000.00 | 481,200.00 |
| Хоол, хүнс | 17,406,626.00 | 7,320,175.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 793,975.00 | 973,800.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,877,100.00 | 5,254,750.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | | 550,000.00 |
| Тавилга | 3,720,000.00 | |

| | | |
|---|---|---|
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 1,000,000.00 |
| Урсгал засвар | 3,157,100.00 | 3,704,750.00 |
| Томилолт, зочны зардал | 1,850,000.00 | 903,800.00 |
| Дотоод албан томилолт | 1,850,000.00 | 903,800.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,015,622.00 | 1,323,800.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,015,622.00 | 1,083,800.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 240,000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,870,480.00 | 4,299,955.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 345,000.00 | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,525,480.00 | 4,299,955.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,379,566.99** | **34,386,129.14** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 33,807,400.00 | 21,421,500.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,866,400.00 | 19,021,500.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,941,000.00 | 2,400,000.00 |
| **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,718,463.00 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,718,463.00 | |
| **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,853,703.99 | 12,964,629.14 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,853,703.99 | 12,964,629.14 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **29,375,096.00** | **1,257,400.00** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | | |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **1,257,400.00** |
| **Биет ба биет бус хөрөнгө худалдан авах** | | **1,257,400.00** |
| Дотоод эх үүсвэрээр | | 1,257,400.00 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 1,257,400.00 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(1,257,400.00)** |
| **Бусад эх үүсвэр** | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | | |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **29,375,096.00** | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **528,838,633.66** | **549,944,095.48** | **1,774,875,958.68** | **2,853,658,687.82** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **528,838,633.66** | **549,944,095.48** | **1,774,875,958.68** | **2,853,658,687.82** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 6,563,893.62 | 6,563,893.62 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **528,838,633.66** | **549,944,095.48** | **1,779,344,756.30** | **2,858,127,485.44** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 72,867,561.54 | 72,867,561.54 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **528,838,633.66** | **549,944,095.48** | **1,852,212,317.84** | **2,930,995,046.98** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,006,396,200.00 | 1,003,984,815.00 | 2,411,385.00 | 99.76 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,006,396,200.00 | 1,003,984,815.00 | 2,411,385.00 | 99.76 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 983,309,500.00 | 971,098,685.86 | 12,210,814.14 | 98.76 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 669,512,100.00 | 669,512,100.00 | | 100.00 |
| Үндсэн цалин | 429,185,100.00 | 429,185,100.00 | | 100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нэмэгдэл | 169,409,500.00 | 169,409,500.00 | | 100.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 24,150,000.00 | 24,150,000.00 | | 100.00 |
| Урамшуулал | 46,767,500.00 | 46,767,500.00 | | 100.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,821,000.00 | 82,091,366.86 | 1,729,633.14 | 97.94 |
| Тэтгэврийн даатгал | 59,461,000.00 | 57,731,366.86 | 1,729,633.14 | 97.09 |
| Тэтгэмжийн даатгал | 6,089,500.00 | 6,089,500.00 | | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,871,800.00 | 4,871,800.00 | | 100.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,217,800.00 | 1,217,800.00 | | 100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,180,900.00 | 12,180,900.00 | | 100.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 192,520,200.00 | 190,234,145.00 | 2,286,055.00 | 98.81 |
| Гэрэл, цахилгаан | 7,293,900.00 | 5,606,785.00 | 1,687,115.00 | 76.87 |
| Түлш, халаалт | 179,298,300.00 | 179,298,300.00 | | 100.00 |
| Цэвэр, бохир ус | 5,928,000.00 | 5,329,060.00 | 598,940.00 | 89.90 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 8,796,800.00 | 8,785,594.00 | 11,206.00 | 99.87 |
| Бичиг хэрэг | 584,300.00 | 584,300.00 | | 100.00 |
| Тээвэр, шатахуун | 1,250,000.00 | 1,241,750.00 | 8,250.00 | 99.34 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 818,200.00 | 818,200.00 | | 100.00 |
| Ном, хэвлэл | 617,400.00 | 617,400.00 | | 100.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,032,700.00 | 4,032,494.00 | 206.00 | 99.99 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,494,200.00 | 1,491,450.00 | 2,750.00 | 99.82 |
| **Нормативт зардал** | 13,435,900.00 | 8,775,175.00 | 4,660,725.00 | 65.31 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 481,200.00 | 481,200.00 | | 100.00 |
| Хоол, хүнс | 11,980,900.00 | 7,320,175.00 | 4,660,725.00 | 61.10 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 973,800.00 | 973,800.00 | | 100.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,183,500.00 | 5,172,750.00 | 10,750.00 | 99.79 |
| Багаж, техник, хэрэгсэл | 1,200,000.00 | 1,190,000.00 | 10,000.00 | 99.17 |
| Тавилга | | | | |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | | 100.00 |
| Урсгал засвар | 2,983,500.00 | 2,982,750.00 | 750.00 | 99.97 |
| **Томилолт, зочны зардал** | 4,000,000.00 | 903,800.00 | 3,096,200.00 | 22.60 |
| Дотоод албан томилолт | 4,000,000.00 | 903,800.00 | 3,096,200.00 | 22.60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,740,000.00 | 1,323,800.00 | 416,200.00 | 76.08 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 1,083,800.00 | 416,200.00 | 72.25 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 | | 100.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,300,000.00 | 4,299,955.00 | 45.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | | | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,300,000.00 | 4,299,955.00 | 45.00 | 100.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,086,700.00 | 32,886,129.14 | (9,799,429.14) | 142.45 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 23,086,700.00 | 19,921,500.00 | 3,165,200.00 | 86.29 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,186,700.00 | 19,021,500.00 | 3,165,200.00 | 85.73 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900,000.00 | 900,000.00 | | 100.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | | | | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | | | |
| **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 12,964,629.14 | (12,964,629.14) | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 12,964,629.14 | (12,964,629.14) | |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | | | |
| **Дотоод эх үүсвэрээр** | | | | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,006,396,200.00 | 1,003,984,815.00 | 2,411,385.00 | 99.76 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 810,892,500.00 | 810,218,500.00 | 674,000.00 | 99.92 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 810,892,500.00 | 810,218,500.00 | 674,000.00 | 99.92 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 195,503,700.00 | 193,216,895.00 | 2,286,805.00 | 98.83 |
| Орон нутгийн төсвөөс | 195,503,700.00 | 193,216,895.00 | 2,286,805.00 | 98.83 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 549,420.00 | (549,420.00) | |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 549,420.00 | (549,420.00) | |
| **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | | | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | | 58.00 | (58.00) | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Удирдах ажилтан | | 1.00 | (1.00) | |
| Гүйцэтгэх ажилтан | | 33.00 | (33.00) | |
| Үйлчлэх ажилтан | | 24.00 | (24.00) | |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 4,942,200.00 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 4,942,200.00 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 3,442,200.00 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | |
| Үндсэн цалин | | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | |
| **Хангамж, бараа материалын зардал** | | 2,720,200.00 |
| Ном, хэвлэл | | 2,720,200.00 |
| **Нормативт зардал** | | |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 722,000.00 |
| Урсгал засвар | | 722,000.00 |
| **Томилолт, зочны зардал** | | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 1,500,000.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | | 1,500,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,500,000.00 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **Дотоод эх үүсвэрээр** | | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 4,942,200.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 4,942,200.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,942,200.00 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг О.Одончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 21–ний хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмших
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд суралцах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хууль зүй дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант хугацааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,075,075.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,750.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,095,912.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,959.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,489.6 мянган төгрөгөөр буюу 2,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | - |
| Авлага | 1,500.0 | 13,526.9 | 12,026.9 |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 138,651.3 | 150,469.5 | 11,818.2 |
| Үндсэн хөрөнгө | 2,719,476.2 | 2,767,120.7 | 47,644.5 |
| **Нийт хөрөнгө** | **2,859,627.5** | **2,931,117.1** | **71,489.6** |
| Өр төлбөр | 1,500.0 | 122.0 | (1,378.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,858,127.5 | 2,930,995.1 | 72,867.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,859,627.5** | **2,931,117.1** | **71,489.6** |

Авлага дансны үлдэгдэл 13,526.9 мянган төгрөг болж 12,026.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ илүү төлөлтөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,469.5 мянган төгрөг болж 11,818.2 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүйгээр бараа материал авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,767,120.7 мянган төгрөг болж 47,644.5 мянган төгрөгөөр өссөн нь 150,982.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,930,995.1 мянган төгрөг болж 72,867.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,006,396.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,006,396.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөөгүй 1,006,396.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,006,396.2 мянган төгрөгийн төсөв батлалснаас 810,892.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 195,503.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 810,218.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 193,216.9 мянган төрөг, туслах үйл ажиллагааны орлого 549.4 мянган төгрөг, нийт 1,003,984.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 991,020.0 мянган төгрөгийг зарцуулж 12,964.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,003,984.8 мянган төгрөг буюу 99.76 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 12,210.8 мянган төгрөгөөр хэмнэж, урсгал шилжүүлгийн зардлыг 9,799.4 мянган төгрөгөөр илүү зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь НДШ-ийн зардал 1,729.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,286.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,660.7 мянган төгрөгөөр, томилолтын зардал 3,096.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Крвид-19 цар тахлын улмаас улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж хөл хорио тогтоосны улмаас бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоож хязгаарласантай шууд холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

## 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 25 мэдээллээс хугацаандаа оруулсан 22 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 31,880.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | - | - | |
| Албан шаардлага | 1 | 31,880.1 | 1 | 31,880.1 | - | - | |
| Зөвлөмж | 2 | - | 2 | - | - | - | |
| Нийт дүн | 3 | 31,880.1 | 3 | 31,880.1 | - | - | - |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нэг алдаа, зөрчилд нэг зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байгууллагын захирлын тушаалаар комисс томилж тооллого хийж байгаа боловч тооллогын комисс үндсэн хөрөнгийн тооллогод голлон анхаарч бусад хөрөнгө, өр төлбөрийн тооллогыг хийж үр дүнг тооцож баримтжуулсан байдал хангалтгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу тооллогыг иж бүрэн хийж, үр дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдалд анхаарал хандуулах нь зүйтэй байна

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Балансын данстай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:*

Тайлант хугацааны эцэст ХХОАТ-ын тооцоог урьдчилан төлж авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, үнэлгээ, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

*1.2.* *Эрсдэл:*

Төсвийн тухай холбогдох заалт зөрчигдөх

*1.3.* *Өгсөн зөвлөмж*

Төсвийн тухай дээрх заалтуудыг мөрдөн ажиллаж өр, авлага үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | ДГА-2021/1/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургууль** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант хугацааны эцэст өр, авлага үүсгэсэн | - | Зөвлөмж өгөх | Захирал | О.Одончимэг |
| **ДҮН** | | | | | |